



**НИЙСЛЭЛИЙН
СОНГИНОХАЙРХАН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН
ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 1110

Улаанбаатар хот

┌ Үйлчилгээний соёлыг дээшлүүлж ┐
Хариуцлага дэг журмыг сайжруулах
тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.7.2, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 258 дугаар тогтоол, Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны 01 албан даалгавар 2018 оны, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 449 дугаар "Сахилга дэг журам, үйлчилгээг сайжруулах зарим арга хэмжээний тухай" тушаал, Эмнэлгийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.1.2, 4 дүгээр зүйлийн 4.1.3, Хөдөлмөрийн дотоод зүйлийн 2 дугаар зүйлийн 2.6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтан бүр өвчтөнийг найрсгаар угтаж, чиглүүлэн тусалж хүний эрхийг хүндэтгэн, иргэдийн оролцоог дэмжиж, өвчтөн болон ар гэрийнхэнд нь өвчний талаарх мэдээллийг мэргэшсэн, үнэн бодит байдлыг танилцуулж зөв шийдвэрлэх, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, шуурхай, хариуцлагатай ажиллах, өөрсдийн ажлын байрны эрсдэлд үнэлгээ хийж, эрсдэлийг арилгах, багаж тоног төхөөрөмжийн ашиглалт, эм урвалжийн хэрэглээний зохистой, найдвартай, аюулгүй байдлыг ханган ашиглалтыг сайжруулах, хэмнэлтийн талаарх төрийн албан даалгавар, тогтоолыг хэрэгжүүлэн ажиллахыг нийт ажилтнуудад үүрэг болгосугай

2. 2023 онд байгууллагын үйлчилгээний соёлыг дээшлүүлж, хариуцлага дэг журмыг сайжруулан гомдол гаргахгүй зохион байгуулж үр дүнг тооцон ажиллахыг албадын дарга, тасгийн эрхлэгч, ахлах сувилагч нарт даалгасугай.

3. Удирдан зохион байгуулж мэргэжил арга зүйгээр ханган үйлчилгээний стандартыг хэвшүүлэн тогттол сайжруулан ажиллахыг Хүний нөөц хөгжлийн албаны дарга (Б.Сүхтулга), Харилцаа соёл үйлчилгээний албаны дарга (Д.Алтанчимэг) нарт үүрэг болгосугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж сар бүр хариуцлагын нэмэгдлийг олгох асуудлыг шийдвэрлэж ажиллахыг удирдлагын багийн гишүүдэд үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



Ц.ОЛОНБАЯР

3180710005